

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр -5
Шөнө -15

УЛС ТӨР

Г.ЗАНДАНШАТАР: ЗАХИРАЛ ТОМИЛОХЫН ТУЛД БОЛОВСРОЛЫН ХУУЛИЙГ ӨӨРЧЛӨХ ГЭЖ БАЙНА

II нүүрт

СПОРТ

Б.ЕСҮЙ: ОЛИМП, ДЭЛХИЙН ТАВЦАНД МОНГОЛЫНХОО НЭРИЙГ ГАРГАХ Л МИНИЙ ХАМГИЙН ТОМ ЗОРИЛГО

V нүүрт

Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

Кино урлагт мөнгө хаяач

Н.БАТЗАЯА

Манай улсад ёстой нэг бор зүрхээрээ яваа хэсэг хүмүүс бол кино урлагийнхан. Ингээд хэлчихэд үгүй гэж мэтгэх хүн нэг их гарахгүй биз. Одоогоос хоёр сар гаруйн өмнө нэгэн жүжигчинтэй ярилцлага хийж байхад Монголын уран бүтээлчид нэг кино бүтээх, бүтээсэн киногоо олон улсын наадамд оролцуулах гэж ямар их зовлон, бэрхшээлийг туулдаг талаар өгүүрсэн нь одоо ч тод санагдаж байна. Монголын нэрийг дэлхийд танилцуулж, Монгол гэх улсад кино урлаг байдаг юм шүү гэдгийг харуулахын тулд очсон газрынхаа гудамжинд хонох нь холгүй зүтгэсний эцэст киногоо олон улсын наадамд өрсөлдүүлдэг хэмээн ярьж байсан.

Үргэлжлэл нь III нүүрт

ХЭН ЮУ ХЭЛЭВ

Э.ТУУЛ

Өнгөрсөн долоо хоногт Ерөнхий сайд асан Н.Алтанхуягтай холбоотой асуудлууд өрнөж, АТГ-аас түүнийг дуудан байцаалт авсан. Түүнчлэн "Хөгжлийн банк"-нд хийсэн шалгалт, "Чингис", "Самурай" бондоос авсан зээлийн асуудал зэрэгтэй холбоотой асуудлууд яригдаж, нэр холбогдсон хүмүүс нь байр сууриа илэрхийлэв. Ингээд энэ долоо хоногт өрнөсөн үйл явдлын талаар "Хэн юу хэлэв" булангаараа онцолж байна.

Н.Алтанхуяг: Шоронд хийсэн ч бууж өгөхгүй тэмцэлдэнэ

/Ерөнхий сайд асан/

-Арваннэгдүгээр сарын 29-ний 14:00 цагийн орчимд надад зарлан дуудах бичиг ирсэн болохоор ирж байна. Ерөнхийлөгчид нэр дэвшинэ гээд хэлчихсэн чинь нэлээд их үйл явдал өрнөх шинжтэй. Хэд хоногийн өмнө нэвтрүүлэгт орж, Монголын нийгэмд болохгүй байгаа асуудлууд,

тэр дундаа цөөхөн хэдхэн хүн Монголын хамаг баялгийг буюу "Оюутолгой", "Тавантолгой", "Эрдэнэт", "Саусгоби Сэндс" гээд сорчлоод завшаад байгааг хэлчихсэн. Тэгсэн Ц.Элбэгдорж болоод тэдний бүлэглэл амь тавьж байгаа бололтой юм. Цөөхөн хоногийн дотор 3-4 эмэгтэй хүнийг шоронд хийлээ. Өнөөдөр харин намайг ир гэлээ. Тэгээд би ирж байгаа юм. Ер нь манай Ерөнхийлөгч болон түүний бий болгочихсон хууль, хяналтын байгууллага дотор нэг хонгил байдаг гэж би өнгөрсөн дөрөвдүгээр сард хэлж байсан.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

13 аймгийн 95 суманд өвөлжилт хүндэрч болзошгүй гэв

Н.БАТЗАЯА

Хүнс хөдөө аж ахуйн яамнаас улсын хэмжээнд 13 аймгийн 95 суманд өвөлжилт, хаваржилт хүндэрч болзошгүй нөхцөл үүссэн хэмээн өчигдөр мэдээлэл хийлээ. Зудын эрсдэлийн зургийг өнгөрсөн сарын 22-нд дахин шинэчилж гаргасан мэдээлэл дээр тулгуурлан дараах тоо баримтыг гаргажээ. Тухайлбал, арваннэгдүгээр сарын 22-ны байдлаар нийт нутгийн 70 орчим хувь зудын их, бага эрсдэлтэй байгаа аж. Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Ховд, Увс аймагт цас их унаснаас малчид өвөлжихөд хүндрэлтэй болжээ. Улмаар малчдыг яаралтай нүүлгэх ажлыг зохион байгуулсан байгаа аж. ХХААЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Чой-Иш "Ховд аймгийн урд гурван суманд цас их унаж, зам даваа хаагдсан байсан. Тиймээс Алтай сумын 86 малчин өрхийг өвлийн нүүдэл зохион байгуулж, их цаснаас холдуулах арга хэмжээ авсан. Увс аймгийн хойд талын сумдад 35-40 см цастай байна. Тэндэхийн малчид ч сум дотроо нүүдэл хийсэн" гэв.

Үргэлжлэл нь IV нүүрт

МЭДЭГДЭЛ

Ардчилсан намын нэр хүндийг гутаах, хагалан бутаргах зорилгоор манай намын нэр бүхий улстөрчдийг санаатайгаар гутаан доромжилж, нэр хүндэд нь халдан ээлж дараалан үндэслэлгүй шалтгаанаар, хууль бусаар баривчилж, хянах шалгах, ял тулгах хэлмэгдүүлэлт, хүчирхийллийн үйл ажиллагааг улс төрийн захиалгаар явуулж байгаагаар холбогдуулан Ардчилсан намын гүйцэтгэх зөвлөлөөс мэдэгдэл гаргаж байна.

Өнгөрсөн дөрвөн сарын хугацаанд хэдэн арван мянган төрийн албан хаагчдыг хоморголон халж, Төрийн өндөр албан тушаал хашиж байсан хэдэн арван хүмүүсийг шалгах нэрийн дор хэлмэгдүүлэн, хүчирхийлж, энэ үйлдлээгэр бүл, хамаатан садан, найз нөхөд, ойр дотны хүрээлэл рүү нь чиглүүлж, хүний эрх, эрх чөлөө, хууль ёс, Ардчилсан тогтолцоонд аюул занал учруулж, коммунист хэлмэгдүүлэлтийн "хар цаг үе"-ийг нийгэмд сануулж байна.

Улстөрчид болон төрийн албан хаагчдыг хоморголон хэлмэгдүүлж, их хэлмэгдүүлэлт явуулж байгаад Ардчилсан нам, намын жирийн гишүүд

**Монгол төр түвшин, Түмэн олон амар амгалан байх болтугай!
АРДЧИЛСАН НАМЫН ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨЛ
2016 оны 11 дүгээр сарын 30**

“Эрдэнэт үйлдвэр”-ийнхэн импорт орлох бүтээгдэхүүн, өнхрөвч үйлдвэрлэх шинэ шугамаа нээлээ

байсан олон бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, гадагшаа урсдаг байсан мөнгөн урсгалыг хэмнэж чадсан билээ. Тэгвэл дахин нэг импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж, угсрах хүчин чадал бүхий хагас автомат бүхий шугамыг нээх ёслолын ажиллагаа өвлийн дунд сарын шинийн нэгний билэгт сайн өдөр боллоо. Энэ нь “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Засвар механикийн заводын 2016 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан туузан дамжуулгын өнхрөвч үйлдвэрлэх шугамыг ашиглахад оруулсан явдал байв.

Үргэлжлэл нь IV нүүрт

БИД ТАНЫ АЖЛЫГ ХҮНДЭЛНЭ

Алдаж болохгүй алтан боломж

Dell –ийн Inspiron, Vostro загварын компьютер худалдан аваад 25.000₮-ийн ваучер бэлгэнд аваарай.

Free Bag + 2 Years + McAfee SECURE

BSB Better Lifestyle | PC mall | itzone Accelerate Your Success

| ХААН банк | Авах | | | Зарах | | | Хуудалгаа хөгжлийн банк | Авах | | | Зарах | | |
|-----------|-----------|---------|-------|---------|---------|--------|-------------------------|-----------|---------|-------|---------|-------|--------|
| | АМ.ДОЛЛАР | ЕВРО | ИЕН | ФУНТ | РУБЛЬ | ЮАНЬ | | АМ.ДОЛЛАР | ЕВРО | ИЕН | ФУНТ | РУБЛЬ | ЮАНЬ |
| | 2462.00 | 2575.00 | 21.30 | 2471.00 | 2644.00 | 21.72 | | 2460.00 | 2577.00 | 21.26 | 3050.00 | 37.25 | 355.00 |
| | | | | 3032.00 | 36.60 | 355.50 | | 2474.00 | 2665.00 | 21.99 | 3150.00 | 40.76 | 360.40 |
| | | | | 3135.00 | 40.00 | 358.90 | | | | | | | |

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

Г.ЗАНДАНШАТАР: ЗАХИРАЛ ТОМИЛОХЫН ТУЛД БОЛОВСРОЛЫН ХУУЛИЙГ ӨӨРЧЛӨХ ГЭЖ БАЙНА

Ж.ОТГОН

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан 51,3 хувьтай эхэллээ. Чуулганаар хамгийн түрүүнд Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцлээ. Үүнд Н.Мандуулыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилж, Ж.Цэрэнрагчаагийн бүрэн эрхийн хугацаа дууссан тул Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнээс чөлөөллөө. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулж УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн "Нэр дэвшигчийг дэмжиж байна. Өөрөө Сангийн яаманд санхүүгийн зах зээлийн чиглэлээр ажиллаж байсан байна. Санхүүгийн салбарт хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх асуудал чухал. Ингэж чадвал зээлийн хүү өрсөлдөөний зарчмаар буурна. Гэтэл ахиц гарахгүй байна. Тиймээс хувь хүний хувьд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх тал дээр юу хийнэ гэж бодож байна вэ" гэв. Түүний асуултад Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшиж буй Н.Мандуул "Тантай санал нэг байна. Хороо бол хурлын зарчмаар шийдвэр гаргадаг. Түүнд Сангийн яаманд ажиллаж байсан хүний үүднээс дуу хоолой болно. Би хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр гурван жил хийхээр төлөвлөсөн" гэлээ. Ингээд УИХ-ын чуулганы хуралдааныг тоймлон хүргэе



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

МҮОНРТ-ээр зар явуулахыг хориглосон засварыг хуульд оруулаагүй гэв

Үүний дараа Олон нийтийн радио, телевизийн Үндэсний Зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцлээ. Үүнд МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр Х.Чилаажавыг томилж, А.Мөнхбатыг МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөллөө. Хэлэлцүүлгийн шатанд УИХ-ын гишүүн Ц.Нямдорж "МҮОНРТ-ийг Засгийн газрын харьяанд ажиллуулдаг ч юм уу гэсэн бодол төрөх боллоо. Эсвэл хуулийг нь хүчингүй болгоод шинэ хууль оруулж ирмээр юм. Тэгэхгүй бол энэ газар чинь луйврын үүр болоод байна. Хэрэгждэггүй хууль, хэрэгжүүлдэггүй дарга эзэртэй байх юм бол энэ газрыг Засгийн газрын харьяанд авмаар байна. Та нар МҮОНРТ-ийн хуулийг хэрэгжүүлж чадах юм уу, үгүй юм уу" гэв. Түүний асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд "МҮОНРТ-д хууль хэр зэрэг хэрэгжиж байгааг шалгасан. Энэ байгууллагын даргаар өөр албан тушаал хашиж байсан хүнийг томилсон байсан. Энэ байгууллагын цаашдын хувь заяа энэ хэвээр явах нь зүгээр. Харамсалтай нь МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл ажлаа хийж чадахгүй байна. МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийг УИХ-аас томилдог. Нэгэнт томилсон юм чинь Үндэсний зөвлөл ажлаа хийхгүй бол харилцаагаа тооцдог болбол зүгээр юм байна билээ. Цаашид шаардлагатай гэж үзвэл хуульд нь нэмэлт өөрчлөлт оруулаад, Үндэсний зөвлөлийг

ажлаа хийхэд шаардлага тавьж ажилладаг болбол зүгээр юм гэж бид байнгын хороон дээр ярилцсан" гэв. Түүнчлэн УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл "МҮОНРТ-ээр зар сурталчилгаа явуулахыг хориглосон засварыг 2005 оны хоёрдугаар сард хийхээр хэлэлцэж баталсан. Гэтэл энэ засварыг хуульд оруулаагүй. Яагаад засвараа хуульд оруулаагүй вэ гэдгийг өнөөдөр ярих ёстой. МҮОНРТ гурван тэрбум төгрөгийн өрөнд дарагдсан гэж ярьж байна билээ. Үүнийг яах ёстой юм бэ. Телевиз үздэг бүх хүнээс хураамж авдаг атал өрөнд ороод сууж байдаг. Дээр нь 13 тэрбум төгрөг улсын төсвөөс авдаг. Энэ хөрөнгөөр зар сурталчилгаа явуулахгүйгээр хангалттай амьдраад явах боломжтой мөнгө. Би Х.Чилаажавын тухайд мэднэ. Энэ хүнийг оруулж ирж байгаад бүрэн дэмжиж байна. Тиймээс энэ байгууллагын дутагдлыг арилгана гэдэгт бүрэн дүүрэн итгэлтэй байна" гэв.

С.Чинзориг: С.Эрдэнэ нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр барилга байшин, хашаа хайс барьсан

УИХ-ын чуулганаар хэлэлцсэн дараагийн асуудал бол "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төсөл байлаа. Энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэх нь зүйтэй гэж үзээд, дэмжив. Хуулийн төсөлд Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яам нэрээ сольж

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болсон. Мөн Хууль зүйн яам болж зүй дотоод хэргийн яам болж нэрээ сольсонтой холбоотой зарим нэр томьёог өөрчлөх асуудлыг тусгасан юм. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулж УИХ-ын гишүүн С.Чинзориг "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийг чадвартай болгох талаар юу бодож байна. Өмнө нь С.Эрдэнэ сайд байхдаа үндэсний зөвлөлийг сайд өөрөө ахалдаг болсон. Ингэснээр өнгөрсөн дөрвөн жилд сайнаас илүү муу нь давамгайлсан. Тэд Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр барилга байшин, хашаа хайс барьсан. Тиймээс цаашид Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийг сайд ахалдаг байх нь хэр оновчтой вэ. Энэ зөвлөл өөрөө чадавхи муутай учраас сайдын үгээр явчих гээд байдаг талтай. Харин Эрүүл мэндийн сайдыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд оруулж өгвөл эрүүл мэндийн салбартгаа уялдаж ажиллах давуу талтай байх болов уу" гэв. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд нийгмийн даатгалын сангийн орлого зарлагад хяналт тавьдаг чадвартай байх шаардлагатай. Хуульд нийцүүлэх үүднээс Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нар энэ зөвлөлд орж ажилладаг. Салбарын сайд нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийг ахалдаг байх нь сайн ч талтай, сул ч талтай. Ер нь хяналтын тогтолцоог бий болгох үүднээс дэд сайд нь давхар хяналт тавьдаг байсан. Гэвч С.Эрдэнэ сайдын үед сайд дангаараа ахалдаг болсон. Сайд дангаараа ахалдаг байх нь зөрчилдөөн үүсгэхийг үгүйсгэхгүй. Тиймээс

хуульд өөрчлөлт оруулах асуудлыг бид нэлээд нухацтай ярих шаардлагатай байна. Хууль зүй дотоод хэргийн сайдын оронд Эрүүл мэндийн сайдыг оруул гэж байна. Хууль зүй дотоод хэргийн сайд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд байдгаараа байх нь зөв. Ирэх онд Нийгмийн даатгалын багц хууль УИХ-аар хэлэлцэхтэй холбоотойгоор бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтүүд орно. Шинэчлэлийн ажлыг гардан зохион байгуулахад эрс шийдэмгий шийдвэр гаргах шаардлага гарвал миний бие энэ зөвлөлийг ажлаж байвал буруугүй гэсэн хувь хүний бодол байгаа" хэмээв.

Чуулган хаалттай горимд шилжлээ

УИХ-ын чуулганы хуралдааныг үргэлжлүүлэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд, хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ. Хуулийн төслийг гишүүдийн 70 гаруй хувь нь дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох байнгын хороонд шилжүүлсэн юм. Үүний дараа Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлгийг хаалттай горимд шилжүүлэн хэлэлцсэн. Улмаар УИХ-ын үлдээ хойших хуралдааны эхэнд Олон улсын гэрээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж, олонхийн саналаар баталлаа. Хуулийн төслийг танилцуулсны дараа УИХ-ын гишүүн О.Баасанхүү "Арбитрын тухай хууль хэлэлцэх гэж байгаа. Энэ хуультай Олон улсын гэрээний тухай хуулийг давхцуулаад

хамт оруулж ирэхгүй бол гадны лобби явж байж магадгүй гэсэн хардлага байна. Гадны хөрөнгө оруулагчид бол Монгол Улсын хууль, шүүхээр явдаггүй. Тиймээс Олон улсын гэрээний хуульд болгоомжтой хандмаар байна" гэв. Харин Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд "Арбитрын шүүхийн тухай хууль бол Олон улсын гэрээний тухай хуулиас тусдаа асуудал. Арбитрын шүүх бол улс хоорондын маргааныг зохицуулдаг юм. Олон улсын гэрээний тухай хуулийн яг ямар заалт нь Арбитрын шүүхэд очлоо гэхэд олон улсын шүүхийн аманд орчих заалт хууль оруулаад ирсэн бол танд хууль санаачлаад оруулж ирэх эрх нь бий" гэлээ.

“Захирал томилохын тулд хууль өөрчлөх гэж байна”

Дараа нь Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Дээд боловсролын тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болгонд тооцох хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох байнгын хороонд шилжүүлэв. Хэлэлцүүлгийн шатанд УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан "Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт хийж байгаа. Өөрчлөлт нь зөвхөн захирлын томилгооны асуудал болчих вий гэж эмзэглэж байна. Дээд боловсролын тогтолцоонд шинэчлэл хийх шаардлага тулгарсан. Зах зээлийн эрэлт хэрэгцээд тулгуурласан, олон улсын шалгуурт нийцсэн мэргэжилтэн бэлгэх хэрэгтэй. Гэтэл одоо дөрвөн төсөгчийн дунд хоёр ажлын байр байна. Цаашид их дээд сургуулийг хөгжүүлэх, жинхэнэ мэргэжлийн захирал томилдог мерит тогтолцоог бий болгох ёстой. Энэ хуулийн төслөөр захирлын томилгоог хийх биш, их дээд сургуулийн шинэчлэлд анхаарах ёстой шүү" гэлээ. Харин УИХ-ын гишүүн Г.Занданшатар "Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлал ойлгомжгүй байна. Энэ хуулийн төсөлд ТУЗ-ийг Засгийн газрыг гишүүн томилдог, төрийн төлөөллийн хувийг нэмэгдүүлэх гэсэн “хэл амны” хууль оруулж ирлээ. Уг нь боловсролын хуульд боловсролын салбарын асуудлыг тусгасан хууль баймаар. Удирдах зөвлөл нь хэнээс ч хараат бус байж ажлаа хиймээр. Гэтэл захирал томилохын тулд хууль өөрчлөх гэж байна. Бид дэмжихгүй" гэсэн юм.

Ийнхүү дугаар шилжих мөчид чуулганы нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг хэлэлцэж байлаа.

МЭДЭЭЛЭЛ

“Эрдэнэт”-ийн шинэ захирал ажлаа хүлээж авав

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын ажил хүлээлцэх ёслол боллоо. Уг үйл ажиллагаанд Монгол Улсын Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дэд дарга А.Дагвадорж, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга У.Бямасүрэн, гишүүн Г.Нандинжаргал, Б.Доржсэмбэд, Д.Дэмбэрэл, О.Орхон, М.Мөнхбаатар, Орхон аймгийн Засаг дарга Д.Батлут болон үйлдвэрийн удирдлагууд, ажилтнууд оролцлоо. Үйл ажиллагааны эхэнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Ц.Даваацэрэн ажлаас чөлөөлөх тухай, мөн Х.Бадамсүрэн Ерөнхий захирлаар томилох тухай тус үйлдвэрийн тогтоолыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дэд дарга, Ажил хүлээлцэх комиссын дарга А.Дагвадорж уншиж танилцуулав. Үүний дараа Ерөнхий захирал Ц.Даваацэрэн, шинэ ерөнхий захирлаар томилогдсон Х.Бадамсүрэн “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн тамгын алд цэнхэр хадгийн хамт гардуулан өглөө. 2013-2016 он дуустал буюу дөрвөн жил орчим хугацаанд “Эрдэнэт үйлдвэр”-ийн Ерөнхий захирлаар ажиллаж, дэлхийн зах зээл дээр эзсийн үнийн огцом бууралттай, эдийн засгийн хүнд нөхцөл байдалд үйлдвэрийг амжилттай удирдаж ирсэн Ц.Даваацэрэн энэ үеэр хамт олондоо хандаж үг хэлсэн юм. Тэрбээр “Монгол Улсынхаа тэргүүлэх үйлдвэрт, хамгийн шилдэг менежерүүд, сайн ажилтан, ажилчинд та бүхэнтэй дөрвөн жил орчим хамтран ажилласандаа би маш их баяртай байна. Энэ хугацаанд та бид олон зүйлийг хийж бүтээсэн ч бидний ажил хөдөлмөрийн зам бас дардан байгаагүй. Хэдийгээр бидэнд хүндрэл бэрхшээл багагүй байсан ч тэр бүхнийг хамтдаа даван туулж чадсан. Өнгөрсөн хугацаанд



надтай хамтарч, сэтгэлээрээ нэг байж ажилласан та нартаа маш их баярлалаа. Та бүхэндээ ажлын өндөр амжилт хүсье” хэмээн талархлаа илэрхийлэв. Харин “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлаар томилогдсон Х.Бадамсүрэн хэлсэн үгэндээ “Өнөөдөр “Эрдэнэт үйлдвэр”-ийн байдал амаргүй байгаа. Энэ хүндрэл бол хамт олон, удирдлагаас шалтгаалсан гэхээсээ илүү жам ёсны, үйлдвэр олон жил ажиллаж байгаатай холбоотой. Уул геологийн нөхцөл хүндэрч,

хүдэр дэх эзсийн агуулга буурч байна. Ийм нөхцөлд уурхайн гүн рүү хайгуул хийх, нөөц өсгөх боломжийг судлах учиртай. Ил уурхайн хувьд агуулгыг ямар төвшинд хадгалах ёстой, хаягдал бохирдлын хэмжээг оновчтой төвшинд хадгалах гээд судалж, ярилцаж төлөвлөсөн олон ажил байгааг Даваацэрэн захирал надад хэлсэн. Тиймээс түүний хийж байсан энэ сайхан ажлуудыг үргэлжлүүлж, уламжлал шинэчлэлийн зарчмыг барьж ажиллах болно” хэмээсэн юм.

MINFO
МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот
Харилцах утас, факс: 976-70113551
“Монголын мэдээ” сонины редакцт эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр Кино урлагт МӨНГӨ ХАЯАЧ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Хэрвээ манай улс соёлын яамтай, харьяа яамнаас нь кино урлагийг дэмжсэн, хэрхэн хөгжүүлэх талаархи бодлоготойсон бол юунд ингэх билээ. Магадгүй кино урлагийг хөгжүүлэх тодорхой бодлого чиглэлтэй байсан бол харьяа яамных нь сайд өөрийн биеэр уран бүтээлчдээ аваад олон улсын наадамд оролцох байсан биз. Харамсалтай нь бодит амьдрал дээр байдал эсрэгээрээ гэдэг нь бидний нүдэнд илхэн. Бүхэл бүтэн тусгаар тогтносон улсад кино урлагийг дэмжих талаархи бодлого чиглэл ч алга. Ингээд хэлчихвэл юм харж, уншдаггүй юм уу хэмээн шүүмжлэх байх. Унших гээд үзсэн ч Соёлын тухай хуулиар л дуусна. 1996 оноос эхлэн хэрэгжсэн тус хуульд кино үйлдвэрлэлийг хөгжүүлнэ гэх сүржин заалт бий. Гэхдээ тэр заалт эдүгээг хүртэл зөвхөн цаасан дээр л мөнхөрсөөр байна. Ингээд бодохоор кино уран бүтээлчид өдий хүртэл бор зүрхээрээ зүтгээсэр Монгол киног олон улсын төвшинд гаргачихлаа. Хамгийн ойрын жишээ дурьдахад, өнгөрсөн аравдугаар сард ОХУ-ын Уфа хотод гурав дахь удаагаа зохион байгуулагдсан “Мөнгөн морь” кино урлагийн наадамд “Чононгоо” продакшны бүтээсэн “Ээж” уран сайхны кино амжилттай оролцож, шилдэг эмэгтэй дүрийн шагналыг эх орондоо авч ирсэн. Тун удахгүй “Атганд үлдсэн эрдэнэ” кино Оскорын наадамд өрсөлдөх гэж байна. Энэ мэтчлэн дурьдаад байвал олон зүйл бий. Тэр байтугай Монголын жүжигчид Холливудын кинонд хүртэл тоглосон. Нэг үгээр хэлбэл, манай улсын кино урлагт хүчин зүтгэж буй найруулагч, зураглаач, жүжигчид өөрсдийгөө дэлхийн хэмжээнд сэтгэж, дэлхийн хэмжээнд ажиллах чадвартай болохоо харууллаа. Монголын урлагийг дэлхий таалж байна. Одоо харин төр засаг кино урлагтаа жаахан ч гэсэн мөнгө хаяж, уран бүтээлчдээ дэмжвэл яасан юм. Кино урлагаараа дамжуулан богинохон хугацаанд эх орноо сурталчилж өөрийн соёлоо түгээж болдог арга ухааныг БНСУ бидэнд өчнөөн жил харууллаа шүү дээ. Хэдий болтол ард иргэд нь улиг болсон солонгос драм ширтэж, хэдэн уран бүтээлчид нь байр, машин, эд хөрөнгөө барьцаалан барин кино урлагийн төлөө зүтгэж, харин эрх баригчид нь нүд нь балай, чих нь дүлий юм шиг явах гэсэн юм. Хэн ч очихгүй уйтгартай шоу хотын төв талбайд зохион байгуулж, түүндээ хэдэн зуун сая төгрөг хаяж байхын оронд кино урлагтаа мөнгө хая л даа.

Өнгөрсөн аравдугаар сард болсон “Улаанбаатарын намар” шоу хүн бүхэн санаж байгаа байх. Тус шоуны зардал нийт 217.6 сая төгрөг болсон бөгөөд “Камертон”, “Никитон” хамтлагийхан тус тус 50 саяар төгрөгөөр дуулсан гэх. Хэдхэн цаг хоёрхон хамтлаг дуулуудлахын төлөө 100 сая төгрөг зарцуулж л байдаг. Эцэст нь шоу нь сонирхолтой ч болсон юмгүй иргэдээс хий дэмий зүйлд мөнгө үрлээ гэх үнэлгээ аваад дууссан. Энэ мэтчлэн үр дүнгүй ямар ч хэрэгцээгүй зүйлд зуу зуун саяар нь мөнгө цацаж байхынхаа оронд кино уран бүтээлчдээ дэмжих сайхан уран бүтээл гаргачихаад олон улсын наадамд оролц л доо. Ядаж л улсын нэр дэлхийд гарна. Монголын талаар Чингис хаан, морь хоёроос өөрөөр төсөөлөлгүй гадаадын иргэдийн манай улсын талаархи бодол өөрчлөгдөнө. Кино урлагаар дамжуулаад нөгөө их хүсээд байдаг гадаадын хөрөнгө оруулагчдаа ч татах үүд нээгдэнэ. Хамгийн гол нь манай уран бүтээлчид хийж чадаж байгаад гол учир нь байгаа юм. Хийж чадаагүй байсан бол ч яая гэх вэ. Монголын уран бүтээлчид сэтгэхүйн хувьд гадаадын уран бүтээлчдээс дутахааргүй гэдгээ харуулсан. Одоо харин төрийн гар хийгээ хайрлах л үлдэж. Дахиад хэлэхэд кино уран бүтээлчдээ дэмжээд, тэдэнд хөрөнгө оруулалт хийгээч.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



“
 Үүгээгөөд үүдүгээгөө аоод-
 ааеіа аүяүя едәүе аоод-
 ааеіа аүнүй іа. Едәүе
 аоодіа аүяүя оаі ддәі
 аәеёеәә, ө°д°іа°
 і°д°оөәә, үүе д°оñәәі а
 аааәәә н°д°а і°е°°дүе.”

УИХ-ын гишүүн
 Ч.Цэвэр

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ҮЗЭЛ БОДОЛ



Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Ер нь Ц.Элбэгдорж бид нар 1990 оноос ардчиллын төлөө явсан. Ц.Элбэгдоржийн үгэнд заавал орох ёстой. Хэрэв Ц.Элбэгдоржийн үгэнд орохгүй бол шоронд ордог ийм ардчиллын төлөө би яваагүй. Ийм хоёрхон сонголттой ардчилал Монголд байж болохгүй, ард түмэн минь. Ер нь бол би Ц.Элбэгдоржийн үгэнд ормооргүй байна. Харин улс орныхоо төлөө зүтгэмээр байна. Шоронд хийсэн ч гэсэн бууж өгөхгүй тэмцэлдэнэ.

С.Эрдэнэ: Боломж бүрдвэл намын даргад нэр дэвшихээс татгалзахгүй

/УИХ-ын гишүүн, Ардчилсан намын бүлгийн дарга/

ХЭН ЮУ ХЭЛЭВ

2017 онд төлөгдөх өр зээлээс Ардчилсан намын үед авсан нэг ч төгрөг байхгүй. Яриад байгаа “Чингис”, “Самурай” бондын төлөх хугацаа болоогүй. Миний мэдэхээр “Чингис” бондыг 2013 онд таван жилийн хугацаатай авсан. Эргэн төлөгдөх хугацаа нь 2018 оноос эхэлнэ. Аливаа асуудлыг нотлох баримт, бодит байдлаар ярих ёстой. Бүх бурууг Ардчилсан нам руу чихэх гэж оролдох юм. Хөгжлийн банкаас гарсан нийт зээлийн 60 гаруй хувийг МАН-ын гишүүдтэй холбоотой аж ахуйн нэгжүүд авсан байдаг. Гэтэл эд нар яаж ингэж ярьж чадаж байна аа. Хууль зүй, дотоод хэргийн сайдаас эхлээд байна шүү дээ. Сонин хэвлэлээр зөндөө л гардаг. Би нэр цохож хэлмээргүй байна. Ардчилсан намын даргад нэрээ дэвшүүлэх нь хувь хүний эрхийн асуудал. Намын хуучин дүрэмд болон одоо шинээр боловсруулж байгаа дүрэмд энэ асуудал нээлттэй. Миний хувьд эцсийн шийдвэрээ гаргаагүй байна. Гэхдээ үндсэн дүрэм нээлттэй батлагдаад, нам цаашид шинэчлэгдэх боломж бүрдэх юм бол би намын даргад нэр дэвших асуудлаас татгалзахгүй. Н.Алтанхуяг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшинэ гэдгээ мэдэгдсэн. Би олон түмнийг төлөөлж хэлж чадахгүй. Намын шинэчлэл явагдаж байна. Нам шинэчлэгдээд шинэ удирдлага гарч ирээд, нам төлөвшөөд ямар байр суурь барих вэ гэдгээс хамаарна. Н.Алтанхуяг даргын хувьд бол Ерөнхийлөгчид нэр дэвших бүрэн боломжтой. Манай намын бэлтгэгдсэн лидерийн нэг шүү дээ.

Л.Энх-Амгалан:
 Гишүүнийхээ бүрэн эрхээс татгалзаж, шалгуулахад бэлэн

/УИХ-ын гишүүн/

“Хөгжлийн банк”-ны үйл ажиллагаа хийгээд “Чингис”, “Самурай” бондын зарцуулалтад Алын хэсэг шалгалт хийсэн. Ажлын хэсгийн дүгнэлт өнгөрсөн зургадугаар сард гарсан. Тухайн үед МАН-ын 25 гишүүн гарын үсэг зурж, дүгнэлтээ АТГ-г хүргүүлсэн. Хуулийнхан ч эхнээсээ эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн байгаа. Өмнөх дүгнэлтээр “Хөгжлийн банк” олон хуулийг зөрчсөн болох нь илэрсэн. Өөрөөр хэлбэл, УИХ болон Засгийн газраас батлаагүй олон зуун тэрбум төгрөгийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлсэн. Энэ бүхэн нь баримтаар нотлогдсон. Одоогийн Ажлын хэсгийн дүгнэлтээр бол 1.3 их наяд төгрөгийн зөрчил гарсан байна. Дээрх зөрчлөөс гадна гэрээ байгуулаад, гүйцэтгэлээ хийгээд мөнгөө авахдаа төсөвт өртгийн нь 3-4 дахин нэмж авсан олон компани байна. Энэ нь шалгалтаар илэрсэн. Түүнчлэн ямар нэгэн тендергүйгээр төсөл, хөтөлбөрүүдийг шалгаруулж байж. Энэ мэт зөрчил илэрсэн. Нэр устай нь зарлаж болох хэдий ч эхлээд УИХ-ын чуулганы хуралдаан дээр Ажлын хэсгийн шалгалтын дүнг танилцуулна. Түүний дараа бүх зүйл олон нийтэд ил болох байх. Ажлын хэсэг өнгөрсөн зургадугаар сард дүгнэлтээ гаргасан гэдгийг хэлсэн.

Гэсэн ч тухайн үед АН-аас Ажлын хэсэгт орсон гишүүд гарын үсэг зураагүйгээс үүдэж УИХ-аар хэлэлцэж чадаагүй. Гэхдээ шинэ Засгийн газрын Хууль зүйн дотоод хэргийн дэд сайдаар ахлуулсан Ажлын хэсэг шалгаж байна. Тэд дүгнэлтээ УИХ-аар хэлэлцүүлэхээр оруулж ирсэн. Гэвч АН-ынхан завсарлага авлаа. Өөрөөр хэлбэл, АН-ын гишүүд төрийн эрхийг барьж байхдаа шалгалтын асуудлыг хэлэлцүүлээгүй хэр нь, одоо цөөнх болохоор завсарлага авч байна. Өнөөдөр “Хөгжлийн банк”-тай холбоотой санхүүгийн тодорхой хэргүүдийг АТГ-аас шалгаж байгаа. Өөрсдийн хууль зөрчиж хийсэн үйлдлээ халхлах гэсэн бусармаг үйл явдал гэж л харж сууна. АН-ын бүлгийн дарга С.Эрдэнэ нар намайг болон манай намын нэр бүхий гишүүдийн компаниуд нийт зээлийн 60 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг авсан байна гэсэн үндэслэлгүй, нэр төрд халдсан мэдээлэл хийсэн. Би УИХ-ын гишүүн халдашгүй байдлын дэд хорооны дарга Ц.Нямдорж, УИХ-ын Ёс зүйн дэд хороон дарга Д.Лүндээжанцан нарт хандаж, УИХ-ын гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхээсээ татгалзаж, хууль хяналтын байгууллагад шалгуулахад бэлэн байна гэсэн хүсэлт гаргаж байна. Хууль хяналтын байгууллагаар хууль зөрчсөн үйл ажиллагаа нь тогтоогдвол би УИХ-ын гишүүний бүрэн эрхээсээ татгалзахад бэлэн.

Ц.Мөнх-Оргил: Яриа хэлэлцээрээ ойрын хугацаанд эхлүүлбэ гэдэг саналаа хэлсэн

/Гадаад харилцааны сайд/

БНХАУ-тай хийсэн яриа хэлэлцээр тодорхой хугацаагаар хойшилсон. Манай Засгийн газар өөрсдийн байр сууриа БНХАУ-ын талд тодорхой тавьсан. Монгол Улс зарчмын байр сууриа баримталсан хэвээр байгаа. Энэ байдал хоёр улсын харилцаанд нөлөөлөх ёсгүй. Монгол Улс БНХАУ-ын нутаг дэвсгэр, бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолд гүн хүндэтгэлтэй ханддаг хэвээрээ байгаа гэдэг бататгаж хэлсэн. Хоёр талын яриа хэлэлцээрээ ойрын хугацаанд эхлүүлбэ гэдэг саналаа хэлсэн байгаа. Мөн дотооддоо цэгцлэж, УИХ, Засгийн газрын түвшинд ярилцаж тохирох, зөвшилцөх олон асуудал байгаа. Тиймээс одоо энэ ажлуудаа хийж байна. Энэ уулзалтаар дээрх ярьсан асуудлуудаа ярина. Мөн Донорын уулзалт дуусмагц Сангийн сайд Б.Чойжилсүрэн Японд айлчилна. Үүний хажуугаар миний бие Германд очиж Европын түншүүдтэйгээ уулзана. Гэх мэт гэрээ хэлэлцээрүүдээ үргэлжлүүлж байна. БНХАУ-тай хийх



яриа хэлэлцээрийг үргэлжлүүлэх асуудал зөвхөн манай талаас шалтгаалахгүй. Хоёр тал хоорондоо ярьж байж шийдэх асуудал. Тодорхой мэдээлэл ирээгүй байна. Урд хөршийн зүгээс нүүрс, зэсийн татварын үнийг нэмсэн гэсэн мэдээлэл яваад байгаа. Үнэндээ татвар биш хураамж нэмсэн. Шинэ төрлийн хураамж нь “Ганц мод” боомтын тоног, тохөөрөмжийг шинэчлэхэд зориулагдана. Өөрөөр хэлбэл, Монгол Улсаас БНХАУ-руу “Ганц мод” боомтоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнд нэг тонн тутмаас найман юань, нэг машинаас 10 юань, зэсийн баяжмалаас нийт үнийн дүнгийн хоёр хувьтай тэнцэх хураамж авахаар шийдвэрлэсэн. Өнөөдөрөөс энэ хураамжийг авч эхэлж байгаа. Бид БНХАУ-ын талд хураамж нь хэр удаан үргэлжлэх юм, ямар учир шалтгаантай, үүний үр дагавар юу болох вэ, аль болох богино хугацаанд хураамжаа аваад тоног тохөөрөмжөө шинэчлээд эргээд татвараа буулгаач ээ гэдэг саналыг тавьж байгаа.

ЭДИЙН ЗАСАГ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА



маань явагдаад эцсийн бэлэн болсон бүтээгдэхүүн гараад ирсэн, өнөөдөр үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний маань дээж бэлэн болсон байна. Энэхүү өнхрөвчний маань диаметр хамгийн багадаа 80, хамгийн том нь 219, урт нь 2 метр 60 см өнхрөвчийг үйлдвэрлэж байна. Эхний ээлжинд үйлдвэрийнхээ 5000 ширхэг өнхрөвчний захиалгыг гүйцэтгэнэ. Цаашид Монгол Улсын зах зээлд шаардлагатай 5-10 мянган өнхрөвчийг үйлдвэрлэнэ. Өнөөдөр ашиглалтад орж байгаа өнхрөвчний шугам бол 700 гаруй сая төгрөгийн өртгөөр боссон. Өөрийн өртгөө найман сарын дотор нөхөх боломжтой. Манай энэхүү шугам үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр Монгол Улсад дамжуулгын өнхрөвч үйлдвэрлэж, угсарч эхэлсэн хамгийн анхны аж ахуйн нэгж болж байгаа юм" гэлээ. Энэхүү туузан дамжуулгын өнхрөвч үйлдвэрлэх шугамыг ашиглалтад оруулснаар "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн жилийн хэрэгцээний 4500-5000 ширхэг өнхрөвч, Монгол Улсын жилийн хэрэгцээний 5000 ширхэг өнхрөвч буюу нийт 10000 ширхэг өнхрөвч үйлдвэрлэх боломж бий болж байгаа аж.

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”-ИЙНХЭН ИМПОРТ ОРЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНХРӨВЧ ҮЙЛДВЭРЛЭХ ШИНЭ ШУГАМАА НЭЭЛЭЭ

Үргэлжлэл.
Түүрүүч нь I нүүрт

Нэг жилд 10000 ширхэг туузан дамжуулгын өнхрөвч үйлдвэрлэж, угсрах хүчин чадал бүхий хагас автомат бүхий шугамыг нээх ёслолын ажиллагаанд Төрийн өмчийн хорооны Бодлого зохицуулалтын газрын орлогч дарга А.Дагвадорж, Орхон аймгийн ИТХ-ын дарга П.Пүрэвхагва, Засаг даргын орлогч С.Батжаргал, ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүү, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Ц.Даваацэрэн, Тэргүүн дэд захирал Б.Шинэбаатар, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал бөгөөд Ерөнхий инженер Д.Даваасамбуу, Санхүү эдийн засаг хариуцсан дэд захирал Ж.Эрдэнэбилэг болон цех хэлтэс, нэгжийн удирдлага, Засвар механикийн заводын ажилтан, ажиллагсдын төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд оролцлоо. Ёслолын ажиллагааг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал, Техникийн ухааны доктор, Монгол Улсын Аж үйлдвэрийн Гавьяат ажилтан Ц.Даваацэрэн нээж, хэлсэн үгэндээ “Энэ сайхан өдөр үйлдвэрийн ажилтан, ажиллагсад та бүхэнтэйгээ нэгэн баярт мөчийг хамт өнгөрөөж байгаадаа би туйлын баяртай байна. Танарынхаа дунд орж ирээд, энэ цех дотор зогсож байхад үнэртдэг тэр их эрч хүч, сайхан бүтээн байгуулалт яг одоо үнэртэж байна. 2013 онд би ажлаа аваад, Засвар механикийн заводод хийж болох, бид өөрсдөө хийж чадах импорт орлох бүтээгдэхүүнийг гаднаас худалдаж авахгүй байх шийдвэрийг гаргаж байсныг та бүхэн санаж байгаа байх. Энэ хугацаанд Засвар механикийн заводод хийгддэг импорт орлох бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэж, тэр хэмжээгээр үйлдвэрийн хэмнэлтийн бодлого, эдийн засагт маш өндөр үр өгөөж авчирсныг онцлон тэмдэглэхэд таатай байна. Манай Засвар механикийн заводын хамт олон осол авааргүй ажиллах нөхцлийг сайн хангаж, бүтээмж, инновацийг хөгжүүлэх чиглэлээр санаачилгатай, идэвхтэй ажилладаг нь би сэтгэл өндөр явдгаа энэ дашрамд хэлмээр байна. Өнөөдөр та бидний хамтдаа хүлээн авч буй энэхүү өнхрөвч үйлдвэрлэх шугам бол маш богино хугацаанд өөрийн өртгөө нөхөх шинэ шийдэл бүхий технологи юм. Энэ

...Монгол Улс жилд 20 мянган ширхэг туузан дамжуулгын өнхрөвч хэрэглэдэг. Уг хэрэгцээгээ 100 хувь импортоор авдаг байсан бол “Эрдэнэт үйлдвэр” ХХК туузан дамжуулгын өнхрөвч үйлдвэрлэж, угсрах хагас автомат шугамыг ашиглалтад оруулснаар өөрийн хэрэгцээгээ хангаад зогсохгүй...


ажлыг Б.Чинзориг даргатай Засвар механикийн заводын хамт олон санаачлан эхлүүлсэн бол Б.Баасансүрэн даргатай тус цехийн хамт олон үргэлжлүүлэн дуусгаж, ашиглалтад хүлээн авч байгаад туйлын баяртай байна. Цаашид та бүхэн илүү ихийг санаачлан, олон шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гэдэгт итгэл дүүрэн байна. Засвар механикийн завод зөвхөн дотооддоо төдийгүй дэлхийн хэмжээнд өөрийн бүтээгдэхүүнийг таниулж, Монгол Улсын зах зээлийг бүхэлд нь хангах цаг ойрхон байгаа гэдэгт итгэлтэй байна. Ингээд та бүхэндээ ажлын өндөр амжилт хүсье” хэмээсэн юм. Туузан дамжуулгын өнхрөвч үйлдвэрлэх шугамыг нээх ёслолын ажиллагааны туузыг Төрийн өмчийн хорооны Бодлого зохицуулалтын газрын орлогч дарга А.Дагвадорж, Орхон аймгийн ИТХ-ын дарга П.Пүрэвхагва, Засаг даргын орлогч С.Батжаргал, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захирал Ц.Даваацэрэн, Тэргүүн дэд захирал Б.Шинэбаатар, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал бөгөөд Ерөнхий инженер Д.Даваасамбуу, Санхүү эдийн засаг хариуцсан дэд захирал Ж.Эрдэнэбилэг, Механикийн хэлтсийн дарга Б.Чинзориг нар хайчилсан бол

өнхрөвч үйлдвэрлэх шугамыг асаах анхны товчлуурыг Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал бөгөөд Ерөнхий инженер Д.Даваасамбуу, Механикийн хэлтсийн дарга Б.Чинзориг, Засвар механикийн заводын дарга Б.Баасансүрэн нар дарж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн юм. Ийнхүү үйл ажиллагаагаа ёслол төгөлдөр эхлүүлсэн Засвар механикийн заводын импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж, угсрах хүчин чадал бүхий хагас автомат бүхий шугамыг танилцуулсан юм. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын Үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн орлогч

заводын хамт олон ашиглалтад оруулж, нээж байна. Энэ ажлыг манай заводын хамт олон 2016 оны ажлын төлөвлөгөөндөө тусгасан байсан бөгөөд маш удаан хугацааны турш судалж, хэрэгжүүлээ. Үйлдвэрийнхээ дотоод хэрэгцээг хангахын тулд жилд эхний ээлжинд 5000 өнхрөвч үйлдвэрлэнэ. Дараагийн шатанд Монгол Улсын зах зээлд ойролцоогоор 5000 өнхрөвч үйлдвэрлэх зорилго тавиад ажиллаж байна. Өнөөдөр тоног төхөөрөмж, шугамаанээж байгаадаа баяртай байна” хэмээн сэтгэгдлээ хуваалцав. Харин Засвар механикийн заводын Механик цехийн дарга Д.Галбямба тоног

маань өнхрөвч үйлдвэрлэх цехэд Монгол Улсад анх удаа нүүрсхүчлийн хий, аргоны хүчлийн хий хамтарсан гагнуурын суурь машин ажиллаж байна. Энэ маань дэлхийн өнөөдрийн төвшинд хэрэглэгдэж буй хамгийн сүүлийн үеийн машин. Ингээд эцсийн боловсруулалтын суурь машин дээр гагнагдаж хэрэглэгдэж буй хамгийн сальник, резинийг бүрэн угсарч, эцсийн бүтээгдэхүүн гарах ёстой. Өнөөдрийн байдлаар бид Баяжуулах фабрикт шаардлагатай 159 өнхрөвчийг энэ суурь машин дээрээ хийж, туршиж үзэж байна. Үндсэн үйлдвэрлэл

Тус үйлдвэр өмнө нь жилийн хэрэгцээний өнхрөвчийг 350-400 мянган ам.доллараар гаднаас худалдан авдаг байсан бол Засвар механикийн заводад үйлдвэрлэх болсноор 200 гаруй мянган ам.доллар хэмнэгдэж, эдийн засгийн өндөр үр ашиг гарна гэдгийг мэргэжилтнүүд онцлолоо. Туузан дамжуулгын өнхрөвч үйлдвэрлэхэд турба, сальник, холхивч зэрэг түүхийн эд хэрэгтэй бөгөөд одоогоор тус үйлдвэр үүнийг тодорхой хэсгийг өөрсдөө үйлдвэрлэж үлдсэнийг нь худалдан авч байгаа аж. Ирээдүйд холхивчоос бусад эд ангийг өөрсдөө үйлдвэрлэх зорилт тавин ажиллаж байгаа гэдгээ ч хэлсэн юм. Туузан



дамжуулгын өнхрөвч нь үйлдвэрийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг тоног төхөөрөмж бөгөөд дулааны станцууд, барилгын материалын үйлдвэрүүд, хүнс, уул уурхайн үндсэн үйлдвэрүүд өргөнөөр ашигладаг аж. Монгол Улс жилд 20 мянган ширхэг туузан дамжуулгын өнхрөвч хэрэглэдэг. Уг хэрэгцээгээ 100 хувь импортоор авдаг байсан бол “Эрдэнэт үйлдвэр” ХХК туузан дамжуулгын өнхрөвч үйлдвэрлэж, угсрах хагас автомат шугамыг ашиглалтад оруулснаар өөрийн хэрэгцээгээ хангаад зогсохгүй бусад үйлдвэрүүдэд борлуулах боломж нээгдэж байгаа нь энэ юм.

Д.Даваасамбуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын тушаалын дагуу импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж, угсрах хүчин чадал бүхий хагас автомат бүхий шугамыг Засвар механикийн

төхөөрөмжөө танилцуулав. Тэрбээр “Өнхрөвч үйлдвэрлэх машинуудаа БНХАУ-ын өнхрөвч үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч компанитай хамтран ажиллаж, үйлдвэрлэлдээ нэвтрүүлсэн. Засвар механикийн заводын

СПОРТ



АГУЭРО VS КОСТА: ГООЛЫН ХААДЫН
ТУЛААН

БАГА ДЭЛХИЙН АВАРГА ӨНӨӨДӨР
ЭХЭЛНЭ

VI нүүрт

VIII нүүрт

АМЖИЛТЫН ЭЗЭН

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ



Б.ЕСҮЙ: ОЛИМП, ДЭЛХИЙН ТАВЦАНД МОНГОЛЫНХОО НЭРИЙГ ГАРГАХ Л МИНИЙ ХАМГИЙН ТОМ ЗОРИЛГО

Н.ПУНЦАГБОЛД

Рио-2016 Олимпын наадамд усанд сэлэлтийн төрлөөр оролцсон Монголын шилдэг залуу тамирчдын нэг, Спортын мастер Б.Есүйтэй ярилцлаа.

Монголын тамирчид 13 алтан медаль хүртжээ

Хонконгийн Тусгай олимпын хорооны 40 жилийн ойн нэрэмжит тэмцээн арваннэгдүгээр сарын 24-29-ний өдрүүдэд боллоо. Энэхүү тэмцээнд Зүүн Азийн бүсийн БНХАУ, БНСУ, Тайвань, Макао, Хонконг, Монгол гэсэн зургаан улсын 300 гаруй тамирчид спортын олон төрөлтөд өрсөлдөв. Монголын баг тамирчид энэхүү тэмцээнээс 13 алт, 11 мөнгө, 6 хүрэл медаль хүртлээ. Манай тамирчид хөнгөн атлетик, бадминтон, боулинг зэрэг төрлүүдэд амжилттай оролцож, медальт байрт шалгарчээ.

"Их эе" энэ сарын 10-нд хуралдана

Монголын Үндэсний бөхийн холбооны ээлжит бус "Их эе"-ийн хурал энэ сарын 10-ны өдөр хуралдахаар болжээ. "Их эе"-ийг хуралдуулах ажлын хэсэг өнгөрөгч даваа гарагт хэвлэлийн бага хурал хийсэн билээ. Тус хурлыг Улсын дээд шүүхээс 2003 оны гуравдугаар улиралд багтаан хуралдуулахыг үүрэг болгожээ. Гэвч бөхийн холбооноос хурлыг хийгээгүй учир Нийслэлийн шүүхийн гүйцэтгэх албанаас 2015 оны зургадугаар сард тус холбооны Цэцгийн зөвлөлийг албадан хуралдуулсан байна. Түүнээс хойш маргаантай байсан дээрх асуудал энэ оны тавдугаар сард эцэслэн шийдэгджээ. Ийнхүү Үндэсний бөхийн "Их эе" хурал энэ сард хуралдахаар болж байгаа юм байна. Монголын Үндэсний бөхийн холбооны дүрмийн дагуу "Их эе" хурлын товыг 21 аймгийн Үндэсний бөхийн холбоо, бөхийн дэвжээний тэргүүнүүдэд мэдэгдээд байгаа аж.

-Хэдийгээр Олимпын наадам өндөрлөөд удаж байгаа ч гэсэн ярилцлагаа хоёулаа Риогоос эхэлжээ. Олимпын наадамд оролцсон үеэ эргээд дурсвал?

-Олимпын өмнө дөрөвдүгээр сард Улсын аварга шалгаруулах тэмцээн болсон. Тэр тэмцээнд оролцож, амжилтаа бататгасны дараа Олимпын наадамд оролцох болсноо сонссон. Тухайн үедээ маш их сэтгэл хөдөлж, баярлаж байлаа. Улмаар Олимпын өмнөх бэлтгэлээ АНУ-д базаасан. Америкт хийсэн бэлтгэл үнэхээр их үр дүнтэй болсон. Би жилийн өмнө 50 метрийн өврөөр сэлэлтэд 29:51 секунд сэлж, улсын рекордыг шинэчилж байлаа. 2008 онд Олимпын наадамд оролцож байсан Сайнцэцэг эгчийн тогтоосон найман жил эвдэгдээгүй байсан рекордыг

нь шинэчилсэн. Харин Олимпын наадамд 28:40 секундын амжилт үзүүлж, улсын рекордыг дахин шинэчилсэн. Өөрийнхөө амжилтыг 1.11 секундээр ахиулсан. Нэг секунд гэдэг усанд сэлэлтийн 50 метрийн төрөлд маш их хугацаа. Ерөнхийдөө нэг секундээр амжилтаа ахиулна гэдэг тийм ч амар зүйл биш л дээ.

-Усанд сэлэгчид маань Олимпын наадамд цагаан хуудсаар орж байгаа. Эрхээ авч оролцох боломж хэр ойрхон байгаа юм бол?

-Афины олимпын наадамд хойш цагаан хуудсаар орж байгаа. Ер нь бол эрхээ авч оролцох боломж тун ойрхон байгаа гэж би боддог. Өнгөрсөн даваа гарагт Эрдэнэт хотод Монголын усанд сэлэлтийн аварга шалгаруулах тэмцээн болсон.

Энэ тэмцээнд оролцож, 27:46 секундын амжилт үзүүлж, Олимпын наадамд амжилтаа ахиулсан. Энэ бол Олимпын наадмын эрх авах цагийн үзүүлэлтийг биелүүлэхэд ердөө ганцхан секунд дутаж байна гэсэн үг. Тийм болохоор би дараагийн Олимпын наадамд цагаан хуудсаар биш эрхээ авч оролцох боломж ойрхон байна гэж л бодож байгаа шүү дээ. 2018, 2019 оноос Олимпын эрх олгох тэмцээнүүд болно. Тэр тэмцээнүүдэд оролцож, 26 секундын амжилт үзүүлж чадвал Олимпын наадамд оролцох эрхтэй болно. Би ерөнхийдөө тэр тэмцээнүүдээс л эрхээ авах төлөвлөгөөтэй байгаа.

-Олимпын наадам Бразилд болсон. Цагийн зөрүү, цаг агаарын байдал гээд тамирчдад нөлөөлөх хүчин зүйл их байсан.

Чамд яаж нөлөөлсөн бол?

-Америкт бэлтгэл хийсэн болохоор цагийн зөрүү гарчихсан байсан. Америк чинь Бразилаас цагийн зөрүүгүй шүү дээ. Харин Олимпын наадамд явахаас өмнө Монголд оролцож байгаад л Бразил явсан. Гэтэл Бразилд очоод ханиад хүрчихсэн. Бразилийн өвөл эхэлчихсэн байсан болохоор нэлээд сэрүүн байсан. Тэмцээнийхээ үеэр ханиадтай оролцсон.

Төгсгөл нь VII нүүрт

Карлсен дэлхийн аварга цолоо хамгааллаа

Шатрын насанд хүрэгчдийн ДАШТ өнгөрсөн сарын 11-нд эхэлж, ойрын жилүүдэд болоогүй өрсөлдөөнтэй өрнөсний эцэст 30-ны өдөр өндөрлөлөө. Өнөө цагийн хамгийн шилдэг шатарчдын нэг Магнус Карлсен дэлхийн аварга цолоо хамгаалахын

төлөө, Оросын Сергей Карякин дэлхийн аварга болохын төлөө өрсөлдсөн. Хоёр шатарчны тоглолт тун өрсөлдөөнтэй эн тэнцүү өрнөсөөр үндсэн 12 орог тэнцээгээр өндөрлөсөн юм. Улмаар түргэн тоглолтоор аваргаа тодруулахад Их мастер Магнус Карлсен өрсөлдөгчөө

3:1-ээр хожиж, дэлхийн аварга цолоо хамгаалав. Өдгөө 26 настай тэрээр 13 нас 148 хоногтойдоо Их мастер цолны болзол хангасан. Улмаар 2013 онд ДАШТ-данх удаа түрүүлсэн. Түүнээс хойш дэлхийд өнгөлж яваа билээ.

Я.Зоригтбаатар залуучуудын улсын рекордыг шинэчилжээ

Беларусын Минск хотноо өнгөрөгч сарын 26, 27-ны өдрүүдэд болсон тэшүүрийн залуучуудын Дэлхийн цомын тэмцээнд ОУХМ Б.Сумъяа, ОУХМ Я.Зоригтбаатар нар оролцсон билээ. Энэхүү тэмцээний эрэгтэйчүүдийн ангилалд өрсөлдсөн Я.Зоригтбаатар гурван зайд уралдаж, 500 м-т 37.94

секундын амжилтаар 54 тамирчнаас 34-р байрт орохдоо улсынхаа залуучуудын рекордыг шинэчилэн тогтоосон байна. Тэрбээр 1000 м-т 35, 1500 м-т 39 дүгээр байрт шалгарчээ. Я.Зоригтбаатарын өрсөлдсөн зай тус бүрт 54-58 тамирчин уралдсан юм байна. Мөн эмэгтэйчүүдийн ангилалд

өрсөлдсөн залуучуудын олимпын багийн төрлийн аварга Б.Сумъяа мөн гурван зайд өрсөлдөж, 500 м-т 30-р байрт орсон нь хамгийн өндөр амжилт нь юм. Түүний зай тус бүрт 40 тамирчин өрсөлджээ. Манай тамирчид Хятадын Чаньчун хотноо 21 хоногийн бэлтгэлд хамрагдаж, Беларусыг зорьсон байна.


Хойд туйл руу аялах эрхийн төлөө монгол эмэгтэй өрсөлдөж байна

Хойд туйл руу нохойтой чаргатай аялалд явах оролцогчийн шалгаруулалтад монгол эмэгтэй уулчин өрсөлдөж байна. Шведийн аялал жуучлалын хувцас хэрэглэл үйлдвэрлэгч Fjallraven компаниас жил бүр олон улсын хэмжээнд зохион байгуулдаг энэ аяллын 2017 оны оролцогчдыг шалгаруулах цахим санал хураалтын уралдаанд уулын спортын ОУХМ Д.Эрдэнэтөгтох оролцож байгаа билээ. Тэрбээр өчигдрийн байдлаар саналын тоогоор Вьетнамын Hoang L Giang нэртэй оролцогчийн дараа 5000 гаруй саналын зөрүүтэйгээр хоёрдугаар байранд бичигдэж байсан. 2015 оны аялалд Монголоос Э.Цэрэндолгор анх орж эх орно

сурталчлахаас гадна монгол хүний тэсвэр тэвчээр, хатуужлыг харуулж, ямар ч нөхцөлд дасан зохицох чадвартайг сурталчилж байсан бол 2016 онд Америкаас Б.Загдсүрэн оролцож байсан түүхтэй. Энэхүү аялалд дэлхийн бүх улс орон оролцох боломжтой бөгөөд тухайлсан 12 орон өөрийн улсын нэр дээр ялагчаа тодруулдаг ба бусад улсууд нь БУСАД ОРОН гэсэн ангилалд өрсөлддөг. Манай орон бусад гэсэн ангилалд 200 гаруй оронтой саналын тоогоороо өрсөлддөг байна. Энэ аялалд оролцох нь дэлхийн хэмжээнд өөрийн орныг сурталчлан таниулдаг томоохон хэмжээний сурталчилгаа болдог билээ.

Саналыг дараах маягаар өгнө

Санал өгөх линк <http://polar.fjallraven.com/contestant/?id=348>
Фэйсбүүк хаяг: Erka Erdenee
1-р алхам: VOTE- г дарна
2-р алхам: Login with facebook-г дарна
3-р алхам: Continue as Таны нэр-г дарна
4-р алхам: No thanks -г дарахад Санал өгсөн танд баярлалаа гэж гарна.



ХӨЛБӨМБӨГ



ААОҮӨІ VS ЕІ НОА: ГООЛЫН ХААДЫН ТУЛААН



Н.БОЛД

Английн премьер лигийг тэргүүлж яваа "Челси" болон "Манчестер Сити" клубын тулаан маргааш болох учиртай. Монголын цагаар 20:30 цагт эхлэх энэхүү тоглолтод "Манчестер Сити" талбайдаа "Челси"-г хүлээж авах бөгөөд үндсэндээ довтлогчдын тулаан өрнөнө гэж хэлэхэд болох юм. Премьер лигт "Манчестер Сити"-гийн довтлогч Сержио Агуэро болон "Челси"-гийн Диего Коста нар тус бүр 10 гоолтойгоор мэргэн буучийн жагсаалтыг тэргүүлж байгаа юм. Харин "Этихад" цэнгэлдэх хүрээлэнд хэн нь гоолынхоо тоог нэмэх нь сонирхол татсаар.

Хоёр тоглогч премьер лигт гоол оруулж байгаа үзүүлэлтээрээ тэргүүлж байгаа. "Манчестер Сити"-гийн довтолгоонд гялалзаж буй Агуэро премьер лигт 142 тоглолтод оролцож, 112 гоол оруулж чадаж байна. Оролцсон тоглолтын 78.9 хувьд нь гоол оруулсан гэсэн үг. Үндсэндээ нэг тоглолтод нэг гоол оруулж байгаатай ялгаа алга. Харин "Челси"-д гялалзаж байгаа Диего Коста 64 тоглолтод оролцож, 42 гоол оруулсан бөгөөд 64.6 хувьтай гоолдож байна. Одоогоор хоёр тамирчин адилхан 10 гоолтой байгаа. Харин Агуэро гоолын дамжуулалт өгөөгүй бол Коста дөрвөн оновчтой дамжуулалт хаячихаад байна. "Челси" 13 тойргийн дараах байдлаар 31 оноотой хүснэгтийг

тэргүүлж байгаа бол "Сити" 30 оноотой гуравдугаар байрт бичигдэж байгаа юм. Хоёр баг сүүлийн таван удаа хоорондоо учраа таарахад "Сити" хоёрт нь хожиж, "Челси" нэг ялж, үлдсэн хоёр тоглолтод тэнцжээ. 2016 онд гэхэд хоёр удаа тоглосон. Энэ оны хоёрдугаар сарын 21-нд "FA Cup" тэмцээний хүрээнд "Челси"-гийн талбайд тулахад Лондоны баг 5:1-ээр бутниргэсэн.

Харин дөрөвдүгээр сард премьер лигийн хүрээнд мөн л "Челси"-гийн талбайд тоглоход "Сити" 3:0-ээр буулгаж авчээ. "Манчестер Сити" премьер лигийн сүүлийн таван тоглолтодоо гурав хожиж, хоёр тэнцсэн. "Мидлсбро" болон "Борнмут" клубтэй 1:1-ээр тэнцээд байгаа юм. Харин "Кристал Палас", "Бөрлин" гэсэн хоёр багийг арай гэж 2:1-ээр буулгаж авсан. Тэгвэл "Челси" сүүлийн таван тоглолтодоо нэг л хожигдсон. Гэхдээ тэр нь премьер лиг биш, лигийн цом. Харин премьер лигт бол долоон тоглолт дараалан хожиж, ганцхан гоол алдсан үзүүлэлттэй явна.

Английн лигийн хагас шигшээд "Ливерпүүл" клуб "Саутгэмптон"-тай тулна

Английн лигийн цомын 1/4 шигшээ тоглолтууд өнгөрсөн мягмар, лхагва гарагийн шөнө болж өндөрлөлөө. Мягмар гарагийн шөнө Английн алдарт "Ливерпүүл" клуб доод лигийн "Лидс Юнайтед"-ыг 2:0-ээр буулгаж авсан. Харин "Халл Сити" клуб "Ньюкасл"-тай эн тэнцүүхэн тулсны эцэст торгуулийн цохилтоор буулгаж авсан юм. Тэгвэл лхагва гарагт "Манчестер Юнайтед" клуб талбайдаа "Вест Хэм"-ийг хүлээж авч, 4:1-ээр бутниргэлээ. Энэ тоглолтод Ибра, Марсьяль нар тус бүр хоёр гоол оруулсан. Тэгвэл "Арсенал" клуб талбайдаа "Саутгэмптон"-тай тоглож, 0:2-оор хожигдсоноор цомын тэмцээнээс мултарлаа. Харин өчигдөр хагас шигшээн оноолт гарсан юм. Хагас шигшээд "Ливерпүүл" клуб "Саутгэмптон"-тай тулахаар оноолт таарлаа. Харин "Манчестер Юнайтед" харьцангуй гайгүй өрсөлдөгч буюу "Халл Сити"-тэй тулахаар болоод байна.

"Реал Мадрид" Испанийн цомын шөвгийн 16-д үлдлээ

Испанийн лигийн цомын тэмцээний 1/16 шигшээн тоглолтууд өнгөрсөн мягмар, лхагва гарагийн шөнө болсон билээ. Өнгөрсөн лхагва гарагийн шөнө "Реал Мадрид" талбайдаа доод лигийн "Культураль Леонеса" клубыг хүлээж авч, 6:1-ээр буулгаж авлаа. Ингэснээр шөвгийн 16-д шалгарч байгаа юм. "Реал" клубүүдийн дэлхийн аваргад оролцох учраас Лигийн цомын энэ шатны эхний тоглолтоо бусад багаас түрүүлж хийсэн. Эхний тоглолтод тэд сулхан өрсөлдөгчөө 7:1-ээр хожсон юм.

Ингэснээр хоёр тоглолтын нийлбэр дүнгээр 13:2-оор бутниргэлээ. Энэ удаагийн тоглолтод "Реал" голдуухан сэлгээний тоглогчдоо гаргасан. Учир нь маргааш "Барса"-тай тулах гэж байгаа учраас гол тамирчдаа нөөсөн юм. Энэ тоглолтын 1, 42, 87 дахь минутад Диас хет-трик хийсэн бол Хамес 23 дахь минутад нэгийг нэмжээ. Мөн Зиданы хүү Энцо Зидан 63 дахь минутад нэг гоол оруулж, 90 дэх минутад зочин багийн хамгаалагч Цезар Моргадо өөрийнхөө хаалганд гоолджээ. Тэгвэл зочдоос 45 дахь минутад Гонзалес нэр төрийн ганц гоол оруулсан байна.

Майкл Оуэн: Баяр хүргэе Вудберн, надад өөр нэг рекорд байгаа шүү

Английн алдарт "Ливерпүүл" клубын тоглогч асан Майкл Оуэн 17 настай довтлогч Бен Вудберн Мерсисайдны багийн түүхэн дэх хамгийн залуудаа гоол оруулсан хөлбөмбөгч болсонд баяр хүргэжээ. Вудберн Английн лигийн цомын тэмцээний хүрээнд "Лидс" клубын хаалганд гоол оруулахдаа 17 нас 45 хоногтой байсан юм. Харин Майкл Оуэн 1997 онд "Уимблдон"-ы эсрэг "Ливерпүүл"-ийн нэрийн өмнөөс анхны гоолоо оруулахдаа 17 нас 143 хоногтой байсан аж. Тэгвэл Оуэн "Ливерпүүл"-ийн өмсгөлтэйгээр хамгийн залуудаа гоол оруулсан тамирчин болсонд баяр хүргэе, Бен Вудберн. Гэхдээ надад дахиад нэг рекорд байгаа шүү" хэмээн бичсэн байна.

Стеван Йоветич "Фиорентина"-д очихыг хүсч байна

"Интер"-ийн довтлогч Стеван Йоветичын агент багийн удирдлагуудтай уулзаж, үйлчлүүлэгч нь өвлийн солилцооны цонхоор "Фиорентина" руу явах хүсэлтэй байгаа талаар ярилцжээ. Йоветич энэ улиралд тун цөөн тоглолтод оролцсон учраас Европт хөлбөмбөг тоглох эрхээ ч алдах магадлалтай байгаа аж. "Фиорентина" өнгөрсөн зуны солилцооны цонхоор түүнийг авах гэж оролдсон ч чадаагүй. Харин энэ өвлийн солилцооны цонхоор дахин авахаар оролдох магадлал өндөр байна. Хэрвээ энэ наймаа бүтвэл тэрбээр таван жилийн дараа "Фиорентина"-д буцаж очих нь.

ХОЁР БАГТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

● "Сити" хэрвээ хожиж чадвал Пеп Гуардиола Манчестер хотын багийг удирдаад "Челси"-тэй анх тулахдаа хожсон хоёр дахь менежер болно. Өмнө нь 2009-2010 оны улиралд Роберто Манчини л ийм амжилтыг үзүүлж байж. Өмнө нь "Манчестер Сити"-г удирдаж байсан 10 дасгалжуулагчаас итали эр л ийм амжилтыг үзүүлж байсан байна.

● "Манчестер Сити" Пеп Гуардиолагийн удирдлага дор премьер лигийн 13 тоглолтод оролцоходоо ердөө хоёрт нь л гоол алдаагүй байна.

● Сержио Агуэро премьер лигийн хүрээнд "Челси"-тэй хийсэн сүүлийн хоёр тоглолтод дөрвөн гоол оруулсан. Тэр дундаа сүүлийн тоглолтод хет-трик толилуулсан юм.

● "Челси" клуб "Манчестер Сити"-гийн эсрэг хийсэн премьер лигийн сүүлийн дөрвөн тоглолтодоо хожил авч чадалгүй, хоёр тэнцэж, хоёр хожигдоод байна. Энэ нь тус клубын эсрэг хамгийн удаан хожил авч чадаагүй цуврал болж байгаа аж.

● Антонио Конте "Челси"-гийн хамтаар премьер лигт долоо дараалж хожиж, Жозе Моуриньоогоос хойш анх удаа ийм амжилт үзүүлсэн дасгалжуулагч болоод байна. 2006-2007 онд Моуриньо "Челси"-гийн хамтаар есөн тоглолт дараалж хожиж байжээ.

● Диего Коста премьер лигийн 13 тоглолтод оролцоходоо 11 багийн эсрэг гоол оруулах юм уу, гоолын дамжуулалт өгчээ. Харин хоёр багийн эсрэг гоол оруулах юм уу гоолын дамжуулалт өгөөгүй. "Манчестер Юнайтед"-ыг талбайдаа хүлээж авахад болон "Арсенал"-ын талбайд зочилсон тоглолтод л ийм явдал болж.

№6 ЯПОНД АЖИЛ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ, ЭРХЭЛДЭГГҮЙГЭЭС ҮЛ ХАМААРАН БҮХ ИРГЭД ДААТГАЛД ХАМРАГДДАГ УУ?

-Японд ажил хөдөлмөр эрхэлдэг, эрхэлдэггүйгээс үл хамааран бүх иргэд даатгалд хамрагддаг гэж сонссон. Энэ талаар дэлгэрэнгүй тайлбарлахгүй юу?

-Тийм ээ, Японд төрийн албан хаагч, томоохон компаниудын ажилтнууд, жижиг дунд үйлдвэрүүдийн ажилчид, газар тариаланч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан, ажилгүй иргэд гээд Японд амьдарч буй бүх хүн албан журмаар даатгалд хамрагддаг. Үүнд манай улсад тодорхой хугацаанд амьдарч буй гадаад иргэд ч орно. Япон улсын тэтгэврийн даатгалын тогтолцоо нь хэнд ч учирч болох өвчин эмгэг, бэртэл гэмтэл, амь нас, мөн өндөр наслах үеийн аливаа эрсдлүүдээс "хамгаалах" зорилгоор улсын нийт иргэд бие биедээ харилцан тусалж явъя гэсэн зарчмын дор бий болсон.



СПОРТ

АМЖИЛТЫН ЭЗЭН



ОЛИМП, ДЭЛХИЙН ТАВЦАНД МОНГОЛЫНХОО НЭРИЙГ ГАРГАХ Л МИНИЙ ХАМГИЙН ТОМ ЗОРИЛГО

-Чиний хувьд бэлтгэлээ яаж хангадаг вэ. Бэлтгэл хийх орчин байхгүй гэж байна шүү дээ?

-Эрдэнэтийн "Хангарьд" спорт клубын Алтангуяа багш дээр бэлтгэлээ хийдэг. Багштайгаа хамт бэлтгэлээ хийчихээд орой нь хувиараа бодибилдингийн бэлтгэл хийнэ. Ингэсхийгээд л болно доо. Ямар системгүй, өөрийгөө дайчлаад л зүтгэдэг юм. Хэрвээ стандартын бассейнтай болоод, системтэй бэлтгэл хийгээд эхэлбэл арай л өөр болох байх. Ер нь Монголд усан спорт хөгжих боломж өндөр байгаа. Шинэ залуу тамирчид хүч түрч гарч ирж байна. Жаахан дэмжээд өгөхөд л амжилт үзүүлэх боломж өндөр байна.

-Америكت нэг сарын бэлтгэл хийсэн гэсэн. Жинхэнэ утгаараа системтэй бэлтгэл хийгээд ирэхээр өөрчлөлт яаж мэдрэгдэж байх юм?

-Тэнд бол жинхэнэ утгаараа системтэй бэлтгэл хийсэн. Үнэхээр огт өөр юм билээ. Бэлтгэлхийгэсэн зорилготой болоод, үнэхээр гоё байна. Үр дүнгээ ч сайн өгсөн. Усанд сэлэлтийн спортод, тэр дундаа 50 метрийн зайд нэг секунд ахина гэдэг маш их хугацаа.

-Манайтай ойрхон Хятадад гэхэд усан спорт өндөр хөгжсөн. Тийшээ яваад бэлтгэл хийвэл болох байх даа. Гэхдээ зардал мөнгө гэж нэг том асуудал байгаа байх, тийм үү?

-Америكت нэг сар бэлтгэл хийхэд 15 сая төгрөг шаардлагатай болсон. Аав маань л хамаг боломж бололцоогоо шавхаад л намайг Америк явуулсан. Бүхэл бүтэн Олимпын наадамд оролцох явах вэ дээ гэж бодоод л хувиараа зардлаа шийдээд л явсан. Ёстой яаж ийж байгаад л явсан даа. Өнөөдөр гадаадын бүхий л улс оронд стандартын бассейн байна шүү дээ. Гэтэл Монголд л алга.

-Усан спорт бол Монголд тийм ч их хөгжөөгүй, залуу спортын төрөл. Чиний хувьд энэ спортоор хичээллэх болсон шалтгаан юу вэ?

-Аав маань Орост суралцаж байхдаа бассейнд сэлж сурсан юм билээ. Тийм болохоор намайг зургаан настай байх үеэс эхлээд "Хангарьд" спорт төвийн бассейнд дагуулж явдаг болсон. Анх бассейнд явахад өлмийгөө өргөөд ч уснаас толгой цухуйдаггүй л жаахан байлаа. Гэхдээ надад бассейнд явах үнэхээр их

таалагдаж, шаргуу хичээллэж эхэлсэн. Уг нь би зургаан настайдаа бүжиг, төгөлдөр хуурын дугуйланд явдаг, IQ сургалтад суудаг хүүхэд байлаа. Тэр дундаас надад усан спорт маш их таалагдаж, бусад дугуйлангаа орхиж, энэ чиглэлээрээ дагнасан даа. Тэгээд Эрдэнэтэд болдог тэмцээнүүдэд оролцоод л явдаг байлаа. Харин тухайн үед Алтангуяа багш маань надтай уулзаад, "Чи их ирээдүйтэй хүүхэд байна. Ингэж явж байхаар системтэй бэлтгэл хийгээд, Эрдэнэтийн шигшээ багт ор" гэсэн. Тэр үедээ би нэг их сайн ойлгоогүй. Аав, ээждээ очоод хэлсэн чинь оролгүй яах вэ гээд л оруулсан. Нэг хэсэг бэлтгэлийн ачаалаа даахгүй, муухан сэлдэг байлаа. Харин яваандаа гайгүй суралцаж, улсын аваргад анх удаа оролцоод хүрэл медаль авсан. Үнэхээр их баярлаж байлаа. Сүүлдээ мөнгө, алтан медаль хүртээ, амжилтаа ахнулсаар 2014 оноос Олон улсын тэмцээнд оролцож эхэлсэн. 2014 онд Азийн наадамд оролцож байсан юм. Энэ спортоор хичээллэх эхлэлийг аав, ээж маань л тавьж өгсөн дөө. Намайг үнэхээр их дэмждэг. Энэ хугацаанд Азийн наадам, Азийн аварга, Дэлхийн цом, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, Олимпын наадам гээд томоохон тэмцээнд оролцоод байна даа.

-Саяхан Японд Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон шүү дээ. Тэр тэмцээний талаар ярьвал?

-Азийн аваргад тун дажгүй оролцоод ирсэн гэж өөрийгөө үнэлээд байгаа. Олимпын медальтай шилдэг тамирчидтай уралдаад, чамлахааргүй амжилт үзүүлсэн. Би Олимпын наадамд 50 метрийн өврөөр даллах төрөлд оролцоод 28:40 секундын амжилт үзүүлсэн. Харин Азийн аваргад тэр амжилтаа бататгаж, 28:42 секундын амжилт үзүүлээ. Азийн аваргад түрүүлж байгаа тамирчны хувьд 26 секундын амжилт үзүүлдэг. Хэрвээ би системтэй бэлтгэлээ хийгээд явбал тэдний хэмжээнд хүрэх боломж байгаа.

-Олимп, Азийн аваргад үзүүлсэн цагаа сая улсын аваргаар ахиулж, амжилтаа шинэчилсэн гэсэн. Ямар бэлтгэл хийгээд амжилтаа ахиулчихав. Өмнөхөөсөө арай өөрөөр бэлтгэл хийж дээ гэж бодогддоо?

-Өмнө нь хийж байсан бэлтгэлийнхээ ачааллыг

нэмсэн. Өргөж байсан жингүүдээ 5-10 кг-аар нэмж, өргөж эхэлсэн. Усны бэлтгэлээ ч гэсэн илүү хүндрүүлж хийж байгаа. Тэр бүхэн нөлөөлсөн болов уу гэж бодож байна.

-Усанд сэлэлтийн тамирчдын амжилтад нас нөлөөлөх үү. Олимпын наадамд оролцож байгаа шилдэг тамирчид 20 гарчихсан, 30 хүрчихсэн хүмүүс л байх юм. Гэтэл чиний хувьд 16 настайдаа л том тэмцээнд оролцож, шилдгүүдтэй уралдлаа шүү дээ?

-Мэдээж нас нэмэгдэхийн хэрээр ур чадвар, туршлага сайжирна. Гэхдээ миний биений хэмжээ дэлхийд дээгүүр уралдаж байгаа тамирчидтай адилхан. Өндрийн хувьд тэднээс нэг их ялгараад байхгүй. Заримаас нь бага зэрэг намхан байхад нөгөөдөхөөс нь өндөр байх жишээтэй. Тийм болохоор насаар бага гээд тэднээс дутна гэсэн юм байхгүй. Гагцхүү системтэй бэлтгэлийг стандарт орчинд нь хийх л хэрэгтэй байна. Мэдээж би залуу байна, цаашид илүү сайн хичээллээд, амжилт гаргах хугацаа надад хангалттай байгаа шүү дээ. 2020 оны Токиогийн олимпын наадам миний хамгийн том зорилго. Олон хүн надад итгэл найдвар тавьж байгаа. Тэр хэрээрээ ч надад маш их үүрэг, хариуцлага оногдож байгааг мэдэрч, бэлтгэлээ ч эрчимтэй хийх болсон.

-Одоо өөрийн чинь хувьд цагийн үзүүлэлтээ 26 секунд л болгох хэрэгтэй юм байна. Гэтэл Монголд бэлтгэл хийгээд энэ амжилтыг үзүүлж чадах уу. Хийж байгаа бэлтгэлийнхээ эрчмийг нэмээд явахад боломжтой гэж хараад байна уу, яаж амжилтаа ахиулахаар төлөвлөж байна?

-Амжилтаа ахиулна гээд хэтэрхий их нүдэж болохгүй л дээ. Яаж ч бодсон системтэй бэлтгэл хийх л хэрэгтэй байна. Тийм болохоор гадагшаа явж суралцангаа л бэлтгэл хийе гэж төлөвлөж байгаа. Би энэ жил дунд сургуулиа төгсөнө. Төгсөөд гадаадад суралцангаа 2020 оныхоо Олимпын наадамд бэлтгэнэ дээ. Гадаадын тамирчид өдөр нь хичээлээ хийгээд, оройдоо бэлтгэлдээ явдаг системтэй юм билээ. Би ч бас энэ замыг л сонгох бодолтой байна. Одоогоор АНУ, Хятад, Японы тамирчид усанд сэлэлтээр дэлхийд тэргүүлдэг. Би аав, ээж, багштайгаа ярилцаад

Япон руу явсан нь зөв юм байна гэж төлөвлөж байгаа. Японд очоод Токиогийн Олимпын наадамдаа бэлтгэнэ дээ.

-Эрдэнэтэд болсон улсын аваргад мэдээж түрүүлсэн байх. Харин өрсөлдөж байгаа тамирчдын хувьд чадвар ямар байна. Олон хүчтэй өрсөлдөгчид байхын хэрээр хувь тамирчны амжилт өсдөгшүү дээ?

-Улсын аваргад түрүүлсэн. 6-8, 9-11, 12-14, 15-аас дээш насны ангиллаар улсын аварга болсон. Урьдчилсан сэлэлт, финал гэж байна. Урьдчилсан сэлэлтэд олон хүүхэд уралдаад, тав нь финалд үлдэх маягаар явна. Урьдчилсан шатанд миний хажуу замд уралдсан охин надтай яг адилхан цаг үзүүлсэн. 27:76 секундэд хоёулаа зэрэг орсон, энэ бол маш ховор тохиолдол. Тэгэхээр миний хэмжээнд хүрч сэлэхээр тамирчин охид Монголд байгаа биз дээ. Гагцхүү стандарт бассейнд системтэй бэлтгэл хийгээд эхэлбэл тамирчдын ур чадвар дээшилж, өрсөлдөөн ч нэмэгдэнэ. Тэр хэрээрээ тамирчдын чадвар эргээд нэмэгдэх учиртай. Сая харин тэмцээний үеэр бариад орохдоо би гараа эвгүй тулаад, гэмтээчихсэн. Тухайн үедээ гар хөдөлгөөнгүй болчихсон. Гэтэл орой нь финалын уралдаан болох гээд байлаа. Энэ тэмцээн миний 50 метрийн өврөөр сэлэх төрөлдөө нэг номероо авч үлдэх хариуцлагатай уралдаан байсан. Тийм болохоор шүдээ зуугаад сэлсэн. Ингээд финалд уралдаад, 27:46 секундын амжилт үзүүлж, Монголынхоо рекордыг шинэчилж, нэгдүгээр байрт шалгарсан. Маргааш нь 100 метрээр араар сэлэх уралдаантай байсан. Гэтэл орой нь гар хавдаад, аймаар болсон. Эмчид үзүүлтэл шөрмөс нь сунаад, үе хоорон дахь холбоос нь гэмтчихсэн байсан. Нэлээд хүнд бэртэл авчихсан байсан юм билээ. Түүнийгээ мэдэхгүй сэлээд, Олимпын наадамд оролцсон тамирчин гэдэг түрүүлэх л ёстой гэдгийг харуулсан. Хэрвээ гар зүгээр байсан бол би финалд 27:46-гаас ч бага цаг үзүүлэх боломжтой байсан.

-Чиний үндсэн хичээллэж байгаа төрөл чинь 50 метрийн өврөөр даллах. Харин гадны шилдэг тамирчид их олон төрөлд оролцоод байгаа харагддаг. Чиний хувьд тэмцээнд оролцож байгаа төрлүүдээ нэмэх боломж байгаа юу?

-Бид бэлтгэл дээр бүхий л төрлөөр хичээллэдэг. Дөрвөн төрлийн сэлэлт байгаа. Өврөөр, араар даллах, мэлхий, дельфин гээд. Энэ бүх төрлийн сэлэлтээр хичээллэж байж бие жигд хөгждөг, ур чадвар нэмэгддэг. Түүнээс биш ганцхан өврөөр даллах төрлөөр л хичээллэнэ гэвэл ахиц гарахгүй шүү дээ. Миний хувьд 100 метрийн араар даллах төрөлд спортын мастер хийсэн. Тэгсэн мөртлөө миний үндсэн хичээллэдэг, тэмцээнд оролцдог төрөл нь 50 метрийн өврөөр сэлэх. Ер нь болж өгвөл олон төрлөөр Олон улсын тэмцээнд оролцох нь сайхан л байх. Гэхдээ Олимпын наадамд ч юм уу олон төрлөөр оролцоно гэвэл тэр болгонд эрхээ авах ёстой. 50 метрийн өврөөр даллах төрөлд 26 секундын амжилт үзүүлж байгаа тамирчид Олимпын наадамд оролцох эрхтэй болдог гэж ярьсан даа. Түүнтэй адил араар даллах төрөлд тодорхой цаг биелүүлж байж л эрхээ авна. Тийм болохоор хэцүү л дээ. Манайх шиг усан спорт хөгжөөгүй оронд бол нэг л төрлөөрөө сайтар бэлдэж, амжилт гаргахын төлөө хичээхээс өөр боломж бага байна. Тийм болохоор 50 метрийнхээ төрөлд л илүү сайжрахын төлөө хичээнэ дээ.

-Манай шилдэг тамирчдыг гадны орнууд өөрийн нэр оролцуулахаар урих тохиолдол гарч байгаа. Чамд тийм санал ирсэн үү?

-Буриадаас санал тавьсан юм. Манай багт ороод 2020 оны олимп хүртэл бэлтгэл хийгээд яваач. Цалинжуулаад явъя гэсэн. Тэгээд л Буриадын нэрийн өмнөөс тэмцээнд оролцох юм байна л даа. Миний хувьд тэр саналыг хүлээж аваагүй. Аав, ээж маань хүртэл 10 жил Монголынхоо төлөө бэлтгэл хийчихээд одоо гадагшаа явна гэж байхгүй гэсэн. Би Монголынхоо л нэрийг гаргахын төлөө энэ спортоор хичээллэж яваа шүү дээ. Хэдийгээр Монголд энэ спортыг дэмжиж байгаа хүн бага, аав, ээжийнхээ цалингаар бүхнийг болгож байгаа ч гэсэн зорилготой байвал би хүрэхийг хүссэн зүйлдээ хүрэх байх аа.

-Одоо өөртөө тавьж байгаа хамгийн том зорилго чинь юу вэ?

-Дараагийн Олимпын наадамд амжилт үзүүлэхийг л зорьж байна. Монголынхоо нэрийг дэлхий, Олимпын тавцанд гаргах, эх орныхоо тугийг мандуулахыг хүсч байгаа. Энэ бол миний өөртөө тавьсан хамгийн том зорилго.

...Буриадын нэрийн өмнөөс тэмцээнд оролцох юм байна л даа. Миний хувьд тэр саналыг хүлээж аваагүй. Аав, ээж маань хүртэл 10 жил Монголынхоо төлөө бэлтгэл хийчихээд одоо гадагшаа явна гэж байхгүй гэсэн. Би Монголынхоо л нэрийг гаргахын төлөө энэ спортоор хичээллэж яваа шүү дээ...

Төгсгөл. Түүрүүч нь V нүүрт

-Монголд усан спортын хөгжил муу байгаа. Хамгийн чадвартай тамирчид маань гадны шилдэг сэлэгчидтэй уралдахад хаана нь ч хүрэхгүй байна шүү дээ. Чухам юу дутаад байна вэ?

-Манай улсад дэлхийн стандартад нийцсэн 50 метрийн бассейн байдаггүй. Тамирчид бэлтгэл хийх газаргүй л гэсэн үг шүү дээ. Монголд байгаа бассейнүүдэн ихэнх нь 25 метрийнх. 50 метрийн хоёр замтай бассейн нээгдсэн л дээ. Гэхдээ дэлхийн стандартынх биш, сонирхогчдын ордог л бассейн, дээрээс нь төлбөр маш өндөр. Гэтэл дэлхийн стандартын 50 метрийн бассейн гэдэг хамгийн багадаа л зургаан замтай байх жишээтэй. Дээрээс нь төр засгаас тамирчдаа дэмждэггүй. Олон улсын том тэмцээнээс медальтай ирж байж л бага сага дэмжлэг авах болдог. Уг нь миний бодлоор тамирчдаараа Олон улсын тэмцээнээс медаль авахуулахын тулд эхнээс нь дэмжих хэрэгтэй баймаар. Гэтэл тийм биш. Энэ бүхнээс шалтгаалаад усан спорт хөгжиж чадахгүй байна. 25 метрийн бассейнд бэлтгэл хийхээр хэцүү шүү дээ. Мэдрэмжээс авахуулаад бүх зүйл өөр байгаа юм чинь. Стандарт бассейны тал дээр нь л бэлтгэл хийхээр яаж дэлхийн шилдэг тамирчидтай зэрэгцэж уралдах юм бэ.

СПОРТ

ЖУДО

Бага дэлхийн аварга өнөөдөр эхэлнэ

Н.ПУНЦАГБОЛД

Бага дэлхийн аварга бөгөөд Токиогийн "Их дуулга" тэмцээн өнөөдөр эхэлнэ. Жүдо бөхийн бүхий л шилдгүүдийн чансааг шалгадаг энэ тэмцээнд өнөө жил дэлхийн 41 орны эрэгтэй 155, эмэгтэй 132, нийт 287 тамирчин албан ёсоор оролцохоор болжээ. Уг нь 50 гаруй орон мэдүүлгээ өгөөд байсан ч эцсийн дүндээ 41 болж цөөрлөө. Харин манай улсаас эрэгтэй найм, эмэгтэй дөрөв, нийт 12 тамирчин оролцохоор боллоо. Өмнө нь 13 тамирчин мэдүүлэг өгсөн байсан ч эрэгтэйчүүдээс Г.Болдбаатар барилдахааргүй болсон юм. Японоос энэхүү тэмцээнд зохион байгуулагч орон гэдэг утгаараа нэг жинд дөрөв, нийтдээ 56 тамирчнаа барилдуулж байна.

Тэр дунд Таканори Нагасае, Рики Накаяа, Тору Шишиме, Наохиса Такато, Кондо Ами, Шишиме Ай зэрэг



томчууд барилдана. Дэлхийн шилдгүүдээс олон бөхчүүд энэ тэмцээнд оролцож байгаа юм. 66 кг-д гэхэд Олимпын наадмын аварга Италийн Фабио Басиле, Солонгосын шилдэг бөх, Олимпын мөнгөн медальт Ан Баул, Оросоос Хан Магомедов, Михайл Пулаев гэх мэт шилдгүүд өрсөлдөнө. Эмэгтэйчүүдийн 48 кг-д гэхэд манай М.Уранцэцэг, Г.Отгонцэцэг, Японоос Кондо Ами гээд томчууд тулахаар цуглаад байна. Ердөө л хоёр жингийн бөхчүүдээс дурьдахад

л ямархуу чансаатай тэмцээн болох гэж байгаа нь харагдана. Тэгвэл өнөөдөр эрэгтэй 60, 66, эмэгтэй 48, 52, 57 кг-ын жингийн барилдаанууд болох юм. 60 кг-д манайхаас Дэлхийн аваргын мөнгөн медальт Д.Амартүвшин барилдах бөгөөд манай тамирчин эхний тойрогтоо хийлж, хоёрдугаар тойрогт Солонгосын Ким Чан Ёнтои барилдахаар оноолт таараад байна. Тэгвэл 66 кг-ын жинд Д.Алтансүх, Г.Хэрлэн нар барилдана. Д.Алтансүхийн хувьд В хэсгийг тэргүүлж,

эхний тойрогтоо хийллээ. Харин хоёрдугаар тойрогт Колумбийн Хуан Эрнандез болон Испанийн Алберто Гайтеро Мартин нарын аль ялсантай нь барилдана.

Тэгвэл Г.Хэрлэн С хэсэгт багтаж, эхний тойрогтоо Австрийн Гидар Ноамтай учраа таарлаа. Ялж гэмээнэ Словены бөх Адриан Гомбоктай тулна. Эмэгтэйчүүдийн 48 кг-д Дэлхийн аварга М.Уранцэцэг зодоглож байгаа бөгөөд эхний тойрогтоо Чилийн бөх Мэри Де Варгастай барилдахаар

оноолт таарсан. Харин 57 кг-д Олимпын мөнгөн медальт Д.Сумъяа барилдана. Манайх бөх Олимпын наадмаас хойш анх удаагаа тэмцээнд оролцож байна. Тэрбээр А хэсгийг тэргүүлж, эхний тойрогтоо хийллээ. Харин хоёрдугаар тойрогт Хонконгийн Квок Кит Фонг болон Тайландын Юрико Варашна нарын ялсантай нь барилдахаар оноолт таарлаа. Токиогийн "Их дуулга" ангиллын тэмцээний хэсгийн барилдаанууд өнөөдөр өглөө 10:30 цагаас эхэлнэ.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 3
Шөнө -7

Нөгөөдөр
Өдөр 5
Шөнө -8

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ШАР МОРЬ ӨДӨР

Наран ургах шингэх: 08.22-17.01

Үс засуулбал: Эд мал баялаг төгөлдөр болно



Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг луу нөлөөтэй тул элдэв үйлд хяналттай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр баяр баясалын хурит үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадал үүсгэхэд, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйд, дайсныг давахад сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрэг дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой.



Н.Төгсцогт энэ сарын 8-нд долоо дахь тулаанаа хийнэ

Олимп, дэлхийн аваргын мөнгөн медальт Н.Төгсцогт мэргэжлийн боксын рингэнд дэх долоо дахь тулаан арванхоёрдугаар сарын 8-нд АНУ-ын Калифорни мужид болно. Түүний энэ удаагийн өрсөлдөгч Мексикийн боксчин Герман Мераз. Өрсөлдөгч нь 30 настай, нийтдээ 95 тулаан хийсэнээс 55 ялж, 39 ялагдан, нэг тэнцсэн юм байна. Н.Төгсцогтын хувьд 2015 оны гуравдугаар сард мэргэжлийн рингэнд анх гарснаасаа хойш зургаан тулаан хийж, бүх өрсөлдөгчөө нокаутаар ялсан. Энэ удаагийн тулааны тасалбар 60-80 ам.долларын үнэтэй. 65 болон 80 ам.долларын тасалбар аль хэдийнэ зарагдаж дуусчээ.

ДУУЛГАХ СОНИН

Монголын есөн жүдоч Армийн дэлхийн аваргад оролцоно

Швейцарийн Цюрих хотноо энэ сарын 7-12-нд 37 дахь удаагийн жүдо бөхийн армийн ДАШТ болох юм. Энэхүү тэмцээнд нийт 134 орны тамирчид оролцохоор болжээ. Харин манай улсаас Зэвсэгт хүчний "Алдар" спорт хороо 13 хүний бүрэлдэхүүнтэй оролцохоор бэлтгэлээ базааж байгаа юм байна. Монгол Улсын дархан аварга, гавьяат тамирчин Г.Өсөхбаяр аварга баг тамирчдыг ахлан, дасгалжуулагчаар ОУХМ П.Нямлхагва, Д.Батсайхан нар ажиллах ажээ.

Армийн ДАШТ-д оролцох Монгол Улсын баг тамирчид:

- 60 кг: Дагвадоржийн Баярмагнай /ОУХМ/
- 66 кг: Адьяагийн Батсуурь /ОУХМ, Армийн анхдугаар наадмын мөнгөн медальт/
- 73 кг: Эрдэнэтөгтохын Түмэннасан
- 81 кг: Дашцэрэнгийн Сандуйжав
- 90 кг: Гантулгын Алтанбагана /ОУХМ, Гран При ангилалаас 2 мөнгө, 1 хүрэл медальтай/
- 100 кг: Хутагын Цогтгэрэл /ОУХМ, Армийн анхдугаар наадмын хүрэл медальт/
- +100 кг: Өлзийбаярын Дүүрэнбаяр /ОУХМ, Залуучуудын ДАШТ-ий аварга, Азийн наадмын мөнгөн медальт/
- 52 кг: Адьяасамбуугийн Цолмон /ОУХМ, Багийн ДАШТ-ий мөнгөн медальт,
- 63 кг: Болдын Ганхайч /ОУХМ, 2016 оны улсын аварга/

Хүчингүйд тооцов

1211003049 улсын бүртгэлийн дугаартай, 3676986 регистрийн дугаартай Эй жи эм эйч ХХК ньтатан буугдсан тул

1520000046 улсын бүртгэлийн дугаартай, 0010838 гэрчилгээний дугаартай Үрдээ овогтой Цэдэвдоогийн/рд: ОЮ66071510/ байрны гэрчилгээ гээгдүүлсэн тул

Ү-2203008047 улсын бүртгэлийн дугаартай 28673 регистрийн дугаартай орон сууцны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гээгдүүлсэн тул

Ч.Баянжаргалын (регистрийн дугаар: ФЖ62031202) өмчлөгчийн Ү-2205016024 Улсын бүртгэлийн дугаартай байрны гэрчилгээг гэсэн тул тус тус хүчингүйд тооцов.

ЭЛСЭЛТИЙН ЗАР

"Зохиомж" дээд сургууль 2016-2017 оны хичээлийн жилд дараах мэргэжлүүдээр одор, орой, эчнээ, хөрвөх ангид 4 жил, 2.5 жил, 1.5 жилийн бакалаврын ангид нэмэлт элсэлт авна.

1. Телевизийн сэтгүүлч, зураглаач
2. Кино, драмын жүжигчин

3. Кино, телевизийн найруулагч
4. Бага ангийн багш
5. Сургуулийн өмнөх боловсролын багш
6. Эрх зүй
7. Санхүү, банк
8. Нягтлан бодох бүртгэл, татвар
9. Гааль, гадаад худалдаа

Жич:
-IX/1 –нээс хойш судалсан хичээлүүдийг нэмэлт цагаар нохуулнэ
-Өнгөрсөн хугацаанд өөр сургуульд судалсан хичээлүүдийн дүнг тооцож үргэлжлүүлэн суралцах боломж олгоно.

Сэтгүүл зүй, Урлаг судлал, Бизнесийн удирдлага ангиудад магистрын элсэлт авна.
Холбоо барих утас: 70155585, 91111187, 99608440, 80818021

ХЯМДРАЛ, УРАМШУУЛАЛ

Даваа Мягмар Ахагва Пүрэв Баасан Бямба Ням

ЭХНИЙ ҮЗВЭР БҮР ХЯДРАЛТАЙ: Том хүн - 5000Т, Хүүхэл - 4000Т

| Хосуудын өлөр | Оюутаны өлөр | Ахмадын өлөр |
|----------------------------------|----------------------------------|-------------------------------------|
| Хосоороо ирсэн хүн бүрт тасалбар | Өдрийн дурш оюутануудад тасалбар | 10:00-17:00 Цагийн хооронд тасалбар |
| 5000Т | 5000Т | 4000Т |

ТӨРСӨН ӨДРИЙН УРАМШУУЛАЛ

Тасалбаран алааг → Ундаа Пенкери → Умаргүй